

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 16

№ 26/ТУЗ/17

Улаанбаатар хот

“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай”

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3, 2.5, 2.6 дахь заалт, 3 дугаар бүлэг, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.7, Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн Удирдах 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК /цаашид “Компани” гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 11 цаг 00 минутад, зайнаас буюу цахим хэлбэрээр <https://hural.mlholding.mn> холбоосоор хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, нийтэд хүргэх хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар, санал авах хуудасны агуулгыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт авах саналыг урьдчилсан байдлаар болон хурлын үеэр <https://hural.mlholding.mn> холбоосоор хүлээн авч, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангаж ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
5. Цахим хэлбэрээр урьдчилан санал авах болон саналын хуудсыг хүлээн авах хугацааг 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17 цаг 00 минут хүртэл байхаар тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Гүйцэтгэх захирал Г.Хишигбатыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:


1. Тооллогын комиссын дарга: Компанийн Захиргааны менежер Э. Нарангарвуу
 2. Тооллогын комиссын гишүүд: Компанийн Бизнесийн шинжээч Д. Нямжанцан
Компанийн Хүний нөөцийн мэргэжилтэн О. Онон
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
1. Зохион байгуулах комиссын дарга: Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ц. Дуламсүрэн
 2. Зохион байгуулах комиссын гишүүд: Компанийн Захиргааны менежер Э. Нарангарвуу
Компанийн Маркетингийн менежер А. Номиндандарь
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал, баримт бичигтэй танилцах боломжоор хангаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/ болон Хурал зохион байгуулах комисст тус тус үүрэг болгосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичгийн жагсаалт, хурлын зар, санал авах хуудсыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, Компаниас санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д зөвшөөрсүгэй.
13. Хурал хуралдуулах тухай энэхүү тогтоол болон хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Тогтоол гарсан өдрөөс хойш 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
15. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Л. Ганзоригт/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л. ГАНЗОРИГТ

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 сарын 16-ны өдрийн
№ 26/ТУЗ/17 тогтоолын Хавсралт №1



Компанийн нэр	"Монложистикс Холдинг" ХК
Хурал хуралдуулах өдөр, цаг	2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутад
Хурал хуралдуулах хэлбэр, байршил	Зайнаас буюу цахим хэлбэрээр /https://hural.mlholding.mn холбоосоор/


**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ
АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, БЭЛЭН БОЛГОХ
ЭЦСИЙН ХУГАЦАА**

№	Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон баримт бичгийн жагсаалт	Бэлэн болгох эцсийн хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл	2026/04/10
2	Компанийн 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан	2026/04/20
3	Компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайлан	2026/04/10
4	Аудитын байгууллагын дүгнэлт	2026/04/10
5	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт	2026/04/10
6	ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан	2026/04/10
7	Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн төсөл	2026/04/10
8	Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх гэрээ	2026/04/10

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1	Монложистикс Холдинг ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2	Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэж батлах

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 сарын 16-ны өдрийн
№ 26/ТУЗ/17 тогтоолын Хавсралт №2



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр:	"Монложистикс Холдинг" ХК
Хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс оффис, 1101 тоот
Холбогдох утас:	(976) 7701-5454
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр, 11 цаг 00 минут
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Зайнаас буюу цахим хэлбэрээр
Хуралд оролцох хувьцаа эзэмшигч иргэн нь:	Хурал зохион байгуулагдах https://hural.mlholding.mn холбоосоор нэвтэрч, бүртгэл үүсгэн, бүртгэлээ баталгаажуулна.
Цахим хурлын холбоос	https://hural.mlholding.mn холбоосоор
Хурлын төрөл:	Ээлжит
Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр	2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудал	Монложистикс Холдинг ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл
	Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
	Компанийн 2025 оны санхүүгийн тайлан
	Аудитын байгууллагын дүгнэлт
	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
	ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан
	Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн төсөл
	Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх гэрээ
Холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг	Компанийн хувьцаа эзэмшигч нь 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс дараах байршил, цагт холбогдох баримт бичигтэй танилцаж болно. Үүнд:
	https://hural.mlholding.mn холбоосоор аль ч цагт
	Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан, тухайн компанийн ажлын цагаар, хэдийд ч
Саналын хуудас хүлээн авах эцсийн хугацаа, байршил	Ажлын өдрүүдэд 09:00 цагаас 18:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комисстой холбогдож;
	Саналын хуудсыг цаасан хэлбэрээр 2026 оны 4 дүгээр сар 08-ний өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17 цаг 00 минут хүртэл хугацаанд цаасан хэлбэрээр “Монложистикс Холдинг” ХК-ийн байранд, Тооллогын комисст хүлээлгэн өгнө.

Хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн, холбогдох мэдээлэл, холбоо барих	Тооллогын комиссын дарга: Компанийн Захиргааны менежер Э. Нарангарвуу Тооллогын комиссын гишүүд: Компанийн Бизнесийн шинжээч Д. Нямжанцан Компанийн Хүний нөөцийн мэргэжилтэн О. Онон
Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн, мэдээлэл, холбоо барих	Зохион байгуулах комиссын дарга: Ц. Дуламсүрэн /Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/- dulamsuren@monlogistics.mn Гишүүд: Э. Нарангарвуу /Компанийн Захиргааны ахлах мэргэжилтэн/- narangarvuu@monlogistics.mn А. Номииундарь /Компанийн Маркетингийн менежер/- nomiundari@monlogistics.mn Холбоо барих- 7701-5454 дугаарын (3) холбоосоор холбогдоно.

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 сарын 16-ны өдрийн
№ 26/ТУЗ/17 тогтоолын Хавсралт №3

**"МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Саналын хуудас хүлээн авах эцсийн хугацаа: 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цаг

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: **Энгийн**

Эзэмшиж буй хувьцааны тоо, ширхэг:

Үнэт цаасны дансны дугаар:

Бүртгэлтэй ҮЦК-ийн нэр:

№	Хэлэлцэх асуудал	Санал		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах			

Санал өгсөн Хувьцаа эзэмшигч иргэн: /...../
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд, түүнийг төлөөлж: /...../
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Саналын хуудас хүлээлгэн өгсөн огноо:

Хүлээн авсан Тооллогын комиссын дарга/ гишүүн: /...../
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Саналын хуудас бөглөх санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө зөвшөөрсөн/ татгалзсан/ түдгэлзсэн хэсгийн зөвхөн нэг хэсэгт +/- тэмдэглэгээг бөглөнө.
2. Саналын хуудсыг балласан, засварласан, залруулсан болон 2 ба түүнээс дээш хэсэгт +/- тэмдэглэгээг бөглөсөн тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
3. Хэрэв төлөөллөөрөө дамжуулан саналаа өгөх тохиолдолд төлөөлөх эрх олгосон Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд Саналын хуудсаар өгсөн санал нь итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцогдоно.